



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/289

Арвайхээр

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны “Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” хөтөлбөр батлах тухай 101 дүгээр тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Өвөрхангай аймгийн Засаг даргатай 2020 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гудамж талбай, олон нийтийн газар, орон байранд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах зорилгоор сумдын гэр хорооллын гудамж талбай, олон нийтийн газар, орц, аж ахуйн нэгж, байгууллагын гадна болон дотор талыг камержуулах ажлыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдийн сайн дурын үндсэн дээр зохион байгуулах “Камержуулалт-2” аяныг 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. “Камержуулалт-2” аяныг зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Аяныг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа О.Ганбат)-д үүрэг болгосугай.

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нийтлэг үүргийн хүрээнд энэхүү ажлыг орон нутгийн хэмжээнд чанартай зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, аяны үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (А.Отгонцэцэг)-т даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100625

Аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 48 дугаар захирамжийн хавсралт

“КАМЕРЖУУЛАЛТ-2” АЯНЫ УДИРДАМЖ

Зорилго: Өвөрхангай аймагт үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг бууруулах ажлын хүрээнд орон сууцны орчин, гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбай зэрэг газруудыг камержуулж иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Өвөрхангай аймаг, сум, баг, сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгж байгууллага, иргэд

Хугацаа: 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл

Зохион байгуулагч: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар.

Болзолт уралдааны хүрээнд хийгдэх ажлын чиглэл:

1. Сум, баг, хорооны Засаг дарга нар харъяа нутаг дэвсгэрийнхээ сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгж байгууллага, иргэд олон нийтэд болзолт уралдааны зарыг хүргэж, идэвхи санаачлагатай оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээг авах.

2. Болзолт уралдааны хүрээнд сум, баг, сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгж байгууллагаас тухайн орчныхоо камержуулахаас өмнөх болон камержуулсан үеийн байдлыг харьцуулан фото хэлбэрээр баримтжуулан /цаасан болон электрон хэлбэрээр бэлтгэж мөн бичлэг хавсаргаж болно/ тайлагнах.

3. Цагдаагийн газар, хэлтэс, тасаг, хэсэг, хэсгийн төлөөлөгч нар хяналтын камерын чиглэлээр холбогдох хүмүүст зөвлөмж хүргүүлж, мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажиллах.

4. Орон сууц түүний гадна орчин, гэр хорооллын гудамж, хүүхдийн тоглоомын талбай болон гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, үйлдэгдэж болзошгүй эрсдэл бүхий газруудыг сонгон камержуулах.

5. Дүрс бичлэгийн техник, хэрэгсэл нь Монгол Улсын “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, Ерөнхий шаардлага /MNS 6423:2013/ Олон улсын IP67 стандарт” шаардлага хангасан байх.

6. Хяналтын камер суурилуулах, холболтын ажлыг хийхдээ холбогдох хууль тогтоомж стандартыг мөрдөх.

7. Болзолт уралдааны хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэргэжил арга зүйгээр ханган сайн зохион байгуулж ажилласан төрийн алба хаагчийг тусгай шагналаар шагнаж урамшуулна.

Болзолт уралдааны шалгуур үзүүлэлт:

1.Хяналтын камерыг болзолт уралдаан зарлагдсан хугацаанд шинээр суурилуулсан байх.

2.Гадна орчинд суурилуулах камерууд нь -40C-ээс +40C хэмд тэсвэртэй байх.

3.Камер, бичлэгийн төхөөрөмжийн тохиргооны горим нь англи болон Монгол хэл дээр тохиргоо хийгдсэн байх.

4.Бичигч төхөөрөмж нь хяналтын камерын дүрс бичлэгийг 45 хоногоос багагүй хугацаагаар хадгалах.

5.Хяналтын камер байршуулсан орчинд “Хяналтын камертай бүс” тэмдэглэгээг байршуулах.

6.Камержуулахаас өмнөх болон камержуулсан үеийн байдлыг харьцуулан фото хэлбэрээр баримтжуулах.

7.Хяналтын камер төхөөрөмжтэй утасгүй сүлжээ /WiFi/-ээр холбогдсон байж болно.

8.Гадна татагдах кабел шугамыг уян хоолойгоор далдалж 50 см тутамд бэхлэх.

9.Агаараар татах тохиолдолд кабел шугамыг багцалж, троссон утсанд бэхэлж, төгсгөлийг газардуулсан байх.

ШАГНАЛ:

Сум, Баг			
1-р байр	1	Өргөмжлөл	800.000 төгрөг
2-р байр	1	Өргөмжлөл	600.000 төгрөг
3-р байр	1	Өргөмжлөл	500.000 төгрөг

Дүн:1.900.000 төгрөг

Аж ахуйн нэгж байгууллага /Нийтийн эзэмшлийн гудамж, талбай/

1-р байр	1	Өргөмжлөл	500.000
2-р байр	1	Өргөмжлөл	400.000
3-р байр	1	Өргөмжлөл	300.000

Дүн:1.200.000 төгрөг

Сууц өмчлөгч, хөршийн холбооны хяналтын бүлэг

1-р байр	1	Өргөмжлөл	500.000
2-р байр	1	Өргөмжлөл	400.000
3-р байр	1	Өргөмжлөл	300.000

Дүн:1.200.000 төгрөг

Төрийн албан хаагч /Тусгай шагнал/

1-р байр	1	Өргөмжлөл	500.000
2-р байр	1	Өргөмжлөл	400.000
3-р байр	1	Өргөмжлөл	300.000

Дүн:1.200.000 төгрөг

-Аяны сурталчилгааны самбар, зурагт хуудас, шторк, шагналын өргөмжлөл болон бусад зохион байгуулалтын зардалд 800.000 төгрөг

Нийт зардалд:6.300.000 төгрөг

Аяныг дүгнэх:

-Болзолт уралдааны материалыг 2020 оны 12 дугаар сарын 01-ний дотор аймгийн Цагдаагийн газарт ирүүлнэ.

-Болзолт уралдааныг дүгнэх ажлын хэсэг 2020 оны 12 дугаар сарын 05-наас 10-ны өдрүүдэд шалгаруулалт явуулж, дүнг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулна.

-oOo-